



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/147

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дорнод аймагт болох оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдэд зориулан зохион байгуулж буй зүүн бүсийн сургалт, уулзалтын үйл ажиллагаанд Хэнтий аймгийг төлөөлөн орслцох 47 хүнд 2.907.000 (хоёр сая есөн зуун долоон мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010401

Аймгийн Засаг даргын 2022 оны  
03 дугаар сарын 15 өдрийн  
А/Н/7 захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Замын хоолны зардал	47*2	15.000	1.410.000
2	Баннер хэвлүүлэх зардал	2	20.000	40.000
3	Замд хэрэглэх хүнсний зардал	47*4	4.000	752.000
4	Зөвлөгөөний хувцасны зардал	47	15,000	705,000
	Дүн			2.907.000